

ӨГҮҮЛЭЛ

**Хятадын талаарх монголчуудын ойлголтын
тухай судалгааны тойм****Б.Шүрэнтана**

Доктор Ph.D,

Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын төв, Хөх хот, БНХАУ
coral316@163.com;

Хураангуй: Монголчуудын Хятадын талаарх ойлголтын тухай асуудал бол хоёр улсын харилцааны чухал сэдвийн нэг билээ. Энэхүү өгүүлэл академик судалгааны хүрээнд уг сэдвийн судалгааны байдлыг ангилан дүгнэж харуулжээ. Чингэхэд нэгдүгээрт, судалгааны байгууллагуудаас гаргасан Хятадын талаарх монголчуудын ойлголттой холбоотой санал асуулга, тоо баримт нь харьцангуй бодитой тул хэрэглээний ач холбогдол өндөртэй байна. Хоёрдугаарт, Хятадын талаарх монголчуудын ойлголтын тухайд хийгдсэн судалгааны зарим нь харьцангуй бодитой төвийг сахисан, гүнзгийрүүлж судалсан байхад нөгөө хэсэг нь соёл хоорондын мөргөлдөөний онолоор тайлбарлан нэг талыг барьсан, анхнаасаа байр суурь дүгнэлт нь тодорхой, түүх соёлын хүчин зүйлийг хэт дөвийлгөсөн шинжтэй байна. Ерөнхийдөө монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголт нь түүх, сэтгэл зүй, бодит нөхцөл байдал, гадаад хүчин зүйлс зэргийн харилцан үйлчлэлийн үр дүнд бүрэлдсэнийг энэхүү өгүүлэлд дурдах болно.

Түлхүүр үгс: Монгол, Хятадыг танин мэдэх ойлголт, судалгаа, онцлог

Харилцан танин мэдэх байдал улсын ард иргэдийн харилцан (mutual perception) нь улс хоорондын тааламжтай хандах байдал болон харилцааны ойр дотно байдлын нөгөө улсынхаа талаар хэрхэн түвшинг харуулдаг чухал үзүүлэлт төсөөлөн ойлгодог түвшинг тусган бөгөөд уг үзүүлэлт нь тухайн хоёр харуулдаг. XX зуунд Монгол

Received: 14 September, 2021; Accepted: 25 November, 2021

<https://orcid.org/0000-0002-3119-2469><https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Хятадын харилцааны шинж чанар өөрчлөгдөхийг дагаад монголчуудын Хятадын талаарх ойлголт олон янзын хувьсал өөрчлөлтийг туулсан байдаг. Хүйтэн дайны дараа Монгол Хятадын харилцаа салбар бүрт ихээхэн ахицтай хөгжиж, иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн. 1990-ээд оноос хойш монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтын

ерөнхий түвшин яаж өөрчлөгдөв, ямар онцлогтой байв, ямар хүчин зүйл түүний хөгжил өөрчлөлтөд нөлөөлөв гэдэг асуулууд тун сонирхол татна. Одоогоор иргэдийн дунд санал асуулга явуулдаг байгууллага болон эрдэмтэд нь голчлон Монголын болон барууны орнуудынх байдаг бол Хятадын судлаачид энэ талаар төдийлөн анхаардаггүй.

1. Монголчуудын Хятадыг танин мэдэхүйн ерөнхий түвшин, түүний онцлог

1995 оноос хойш Монголын Сант Марал сангаас жил бүр улс төрийн барометрийн судалгааг хийж ирсэн. Уг судалгаа нь Монголын нийгэм улс төр, эдийн засаг, гадаад бодлогын талаар олон нийтийн санал бодлыг нэгтгэн судалсан ерөнхий санал асуулга юм. Санал асуулгад монголчуудын бусад улстай харилцах гадаад харилцааны үзэл бодлын талаар: “Таны бодлоор

Монголын хамгийн сайн түнш орон ямар улс вэ?” гэсэн асуулт байдаг. Судалгаа авагч судалгаанд оролцогчоос хоёр хариултыг авах ба судалгаанд оролцогч 1 дүгээр сонголт, 2 дугаар сонголт гэсэн байдлаар хариулах юм. Энэхүү өгүүлэлд 1997-2007 оны тоон үзүүлэлтийг 2014-2017 оны тоон үзүүлэлттэй харьцуулсан болно. (хүснэгт 1, хүснэгт 2-ыг харна уу)

Хүснэгт 1. Монголчуудын гадаад харилцааг танин мэдэх ойлголтын нөхцөл байдлын хүснэгт (1997-2007)

Хамгийн сайн түнш улс	1-р сонголт		2-р сонголт	
	Хариулсан хүний тоо	Эзлэх хувь	Хариулсан хүний тоо	Эзлэх хувь
ОХУ	14933	54.2	2067	11.4
АНУ	5251	19.0	4009	22.0
Япон	3365	12.2	4220	23.2
БНХАУ	782	2.8	3768	20.7
Европын холбоо	1343	4.9	1565	8.6
Өмнөд Солонгос	1105	4.0	2198	12.1
Бусад	794	2.9	382	2.1
Нийт тоо	27573	100.0%	18209	100.0%

Энэхүү хүснэгт нь Сант Марал сангаас гаргасан тоон үзүүлэлтийн танилцуулга юм¹.

1 Prohl, W. and L. Sumati, People’s Perception of Mongolia’s Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007, Ulaanbaatar: Munkhiin Useg Co.Ltd, 2007, 330-331

Монголчуудын хоёр хөршдөө хандах хандлага нилээн ялгаатай байдгийг 10 жилийн хугацаанд нийт санал асуулгад оролцсон тоог нэгтгэсэн хүснэгтээс харж болохоор байна. Монголчуудын Хятад улсад хандах хандлага ОХУ-той харьцуулахад хол зөрүүтэй байгаа юм. Нийт санал асуулгад оролцож хариулсан хүмүүсийн 54.2% нь ОХУ-ыг Монголын хамгийн сайн түнш улсын эхний сонголт гэсэн бол ердөө 2.8% нь Хятадыг эхний сонголтоор хамгийн сайн түнш улс гэж үзсэн байна. Хятад нь Монголын хоёр хөршийн нэг, гэтэл АНУ (19%), Япон (12.2%), Европын холбоо (4.9%), Өмнөд Солонгос (4%) зэрэг Монголын “Туравдагч хөрш”-үүдээс бага үнэлгээтэй байна. Багахан ч гэсэн нааштай гэж үзэх үзүүлэлт байгаа нь нийт санал асуулгад оролцогчдын 20.7% нь 2 дугаар сонголтоороо Хятадыг хамгийн сайн түнш гэж нэрлэсэн, энэ нь хамгийн сайн түнш улсын 2 дугаар сонголтонд АНУ, Японы дараа гуравдугаарт орж буй үзүүлэлт юм.

Сант Марал төвөөс гаргасан нарийвчилсан судалгаанд, санал асуулгад оролцогч 18-24 насныхны 3.2% нь Хятадыг Монголын хамгийн сайн түнш улс гэсэн бол 60 наснаас дээш насныхны 2.3% нь Хятадад дотно ханддаг гэжээ. Монголчуудын ОХУ-ыг илүүд үзэх хандлагын ялгаа зөрүүг дээрх хоёр өөр үеийхэнд хийсэн судалгааны харьцуулалтаас харж болно. Залуучуудын 39.4%, өндөр настай хүмүүсийн 71.3% нь ОХУ-ыг хамгийн сайн түнш улс хэмээн эхний сонголт болгож хариулсан байдаг. Бага дунд боловсролтой судалгаанд хамрагдагсдын 3.2% нь Хятадыг хамгийн сайн түнш гэж үздэг гэсэн бол дээд боловсролтой хүмүүсийн 3.0% нь Хятад улсад эерэг ханддаг гэсэн байна. Судалгаанд хамрагдсан ажилчдын 2.5% нь Хятадыг эерэгээр танин мэддэг, харин малчид, тариаланчдын 2.7% нь Хятадыг Монголын хамгийн сайн түнш улс гэж үздэг гэжээ².

Хүснэгт 2. Монголчуудын гадаад харилцааг танин мэдэх ойлголтын нөхцөл байдлын хүснэгт (2014-2019)

Хамгийн сайн түнш улс	2014		2015		2016		2017		2018		2019	
	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт
ОХУ	53.3	2.3	56.0	1.3	61.1	5.5	66.6	2.0	69.8	2.1	70.0	10.3
АНУ	7.6	9.6	6.5	7.1	6.8	7.2	6.5	9.9	6.3	10.7	5.6	13.2
Япон	4.8	9.9	7.0	9.4	6.3	9.8	7.3	9.5	5.9	11.1	7.3	14.9
БНХАУ	1.2	16.1	1.3	19.4	1.6	20.2	0.6	21.6	0.8	19.9	2.4	23.2
Европын холбоо	2.8	3.6	2.3	3.6	4.0	4.8	1.6	3.5	1.3	3.8	4.6	8.5

2 Ibid., 335-338.

Хамгийн сайн түнш улс	2014		2015		2016		2017		2018		2019	
	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт	1-р сонголт	2-р сонголт
Өмнөд Солонгос	1.9	6.8	0.7	6.4	1.6	7.6	0.9	8.3	2.4	12.1	4.0	10.8
Бусад	0.8	1.1	0.4	1.2	0.5	0.9	0.8	2.3	1.0	38.5	0.3	0.4
Хариул-аагүй	3.8	50.8	1.8	51.7	1.1	44.1	0.6	43.0	0.7	38.5	0.4	2.0
Мэдэхгүй	23.8	-	21.0	-	17.0	-	15.2	-	11.8	-	5.5	10.8
Нийт	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %	100 %

1997-2007, 2014-2019 оны тоон үзүүлэлтийг харьцуулахад монголчуудын түнш орнууддаа хандах хандлага тодорхой хэмжээнд өөрчлөгдсөнийг харж болохоор байна. Үүнээс ОХУ-д нааштай хандах хандлага нэмэгдсэн байна. 2019 онд судалгаанд хамрагдагсдын 70% нь ОХУ-ыг Монголын хамгийн сайн түнш орон гэсэн байна. Харин АНУ, Японд хандах эерэг хандлага тодорхой хэмжээнд буурчээ. 1997-2007 оны судалгаанд хамрагдагсдын АНУ-ыг хамгийн сайн түнш улс гэсэн дундаж үзүүлэлт 19% байсан бол 2019 онд энэ үзүүлэлт ердөө 5.6% болсон байна. 1997-2007 онд Японыг хамгийн сайн түнш улс гэсэн 1 дүгээр сонголт 12.2%-тай байсан бол 2019 онд 7.3% болж буурсан байна. Дээрх хоёр улсын буусан үзүүлэлтэй жишихэд Хятадад


хандах монголчуудын эерэг хандлага тодорхой хэмжээгээр нэмэгджээ. Хятад улс хэдийгээр хамгийн сайн түнш улсын 1 дүгээр сонголтод эзлэх хувь бага зэрэг буурсан боловч хамгийн сайн түнш улсын 2 дугаар сонголтын үзүүлэлтээрээ АНУ, Японоос хол илүү байгаа юм. 2019 оны санал асуулгад хамрагдагсдын 23.2% нь 2 дугаар сонголтоороо Хятадыг хамгийн сайн түнш улс гэж хариулсан байна.

2016 оны 3 дугаар сард Канадын нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэн (SPDRI) АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Асуулга судалгааны төвийн (Center for Insights in Survey Research, CISR) захиалгаар Монгол Улсад “Монголын олон нийтийн санаа бодлыг тандан судлах нийгмийн судалгаа”-г явуулсан юм³. Доорх

3 Уг судалгааг өрх айл бүрээр очиж нүүр тулж авсан. Судалгааг Монгол Улсын 21 аймгаас 13 аймаг, Улаанбаатар хотыг ангилан сонгож, дараа аймаг сум дүүрэг хороо багаар нь ангилан ялгаж явуулсан. Сонгуулийн насны 18 болон түүнээс дээш насны 5000 хүнийг судалгаанд хамруулсан. Судалгааны итгэлийн түвшин 95%, алдааны хязгаар 1.4%-иас хэтрэхгүй, бутархай тоог бүхэл тоогоор тооцсон учраас зурган хүснэгт дээрх тоон үзүүлэлтийн нийлбэр 100%-тай бүрэн нийцэхгүй байх магадлалтай.

хүснэгт нь монголчуудын бусад улсуудад эерэг сөрөг хандах байдлын талаарх судалгааны үр дүн юм: Гүн цэнхэр өнгө “маш дуртай”, цайвар цэнхэр өнгө “бага зэрэг дуртай”, гүн ягаан өнгө “маш дургүй”, саарал өнгө “мэдэхгүй/хариулахаас татгалзсан”

Зураг 1. Монголчуудын бусад улсуудад хандах байдлын судалгаа (2016)



Зургаас харахад жагсаасан орнуудын дундаас монголчууд ОХУ-д хамгийн эерэг ханддаг бөгөөд судалгаанд оролцогчдын 90% нь ОХУ-д ямар нэг хэмжээгээр “дуртай” (цайвар цэнхэр, гүн цэнхэр өнгөний нийлбэрээр) гэсэн байна. Бусад улс оронд эерэг хандаж буй үзүүлэлт нь Япон 73%, АНУ 71%, Өмнөд Солонгос 58%, Герман 56%, Их Британи 53%, Канад 50%, Энэтхэг 41%, Хятад 41%, Казакхстан 40%, Турк 38%. Харин “таагүй ханддаг” (unfavourability) үзүүлэлтээр Хятад, Хойд Солонгос хамгийн өндөр байна. Судалгаанд оролцогчдын 53% нь энэ хоёр улсад

хандахдаа ямар нэг хэмжээгээр “дургүй” (цайвар ягаан, гүн ягаан өнгөний нийлбэрээр) гэсэн байна. Бусад улсад сөрөг хандаж буй үзүүлэлт нь ОХУ 5%, Япон 11%, АНУ 12%, Герман 16%, Их Британи 16%, Канад 18%, Өмнөд Солонгос 25%, Энэтхэг 25%, Казакхстан 22%, Турк 27%. Мөн уг судалгаанд Монголын хамгийн том худалдааны түнш орны тухай асуулт багтсан бөгөөд 43% нь Хятадыг Монголын хамгийн том эдийн засгийн түнш (greatest economic partner) гэж хэлсэн ч ердөө 5% нь Хятадыг хамгийн том эдийн засгийн түнш байгаасай (preferred greatest economic partner) гэж


хүсдэг гэсэн байна. Оролцогчдын 46% нь ОХУ-ыг хамгийн том худалдааны түнш байгаасай гэж хүссэн байна.

АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Асуулга судалгааны төвийн (Center for Insights in Survey Research, CISR) захиалгаар Монголын хараат бус судалгааны хүрээлэн IRIM 2020 онд “Монголын залуучуудын санал бодлын судалгаа”⁴-г (зураг 2) хийжээ. Монгол Улс бол “Залуучуудын” орон, Монголын Үндэсний статистикийн хорооны (МҮСХ) сүүлийн жилүүдийн

статистик мэдээгээр 40 хүртлэх насны хүн ам Монголын нийт хүн амын 70%-ийг эзэлж байна. Тиймээс залуучуудын дуу хоолой нийгэм олон нийтийн санаа бодлын чухал төлөөлөл болдог.

Монголын залуучуудын бусад улсуудыг танин мэдэх ойлголтын санал асуулгын үр дүн өмнө нь дурдсан судалгааны үр дүнтэй хол зөрүүгүй байгаа юм. Монголын залуучууд ОХУ болон “Туравдагч хөрш”-үүд гэгдэх Япон, АНУ, Өмнөд Солонгос, Канад, Их Британи, Австрали зэрэг улсуудад илүү дотно ханддаг гэсэн байна.

Зураг 2. Монголын залуучуудын санал бодлын судалгаа (2020)



4 Энэхүү судалгааг МҮСХ-ны хүн амын тооцоололд үндэслэн үндэсний хэмжээнд төлөөлөхүйц төлөөллийг сонгохдоо олон үе шатат санамсаргүй түүврийн аргыг ашигласан болно. Түүврийг бүс нутаг, хот хөдөөгийн суурьшлын бүсээр ангилж, давхарга тус бүрээс түүвэрлэх анхан шатны нэгжүүдийг (PSU) санамсаргүйгээр сонгосон. Санал асуулгад 18-40 насны 2494 Монгол Улсын иргэнийг хамруулсан. Түүврийн алдааны хязгаар 95%, итгэлийн түвшинд ±2.0%-иас хэтрэхгүй байна. Хүснэгт зурагт дурдагдах зарим тоон үзүүлэлтүүдийн нийлбэр бутархайн тоймлолтын улмаас 100 хувьтай тэнцэхгүй байх магадлалтай.

Судалгаанд нэрлэгдсэн улсуудаас Монголын залуучууд Хятад, Хойд Солонгост “сайнгүй ханддаг” гэсэн үзүүлэлт мөн л хамгийн өндөр байна. Судалгаанд оролцогчдын 23% нь Хятад, Хойд Солонгост “зарим талаар дургүй” (somewhat unfavorable) гэсэн бол Хятадад 17%, Хойд Солонгост 15% нь “маш дургүй” (very unfavorable) гэж хариулсан байна.

Судалгааны байгууллагуудын хийсэн монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтын судалгаа нь зөвхөн Хятадын тухай асуудлаар хийсэн тусгайлсан судалгаа биш монголчуудын гадаад харилцааны талаарх ойлголт танин мэдэхүйн ерөнхий хандлагыг судалсан судалгаа байсан бөгөөд санал асуулгын асуулт нь харьцангуй товч тодорхой байсан юм. Дээрх судалгаанууд сонголтын тохиргооны хувьд санал асуулгадаа ямар нэгэн сонголт өгөөгүй, зөвхөн судалгаанд оролцогч өөрөө хариултаа хэлэх эсвэл дотно хандах хандлагын түвшингээ өөр өөр үзүүлэлтээр илэрхийлэх сонголтууд байсан. Ерөнхийдөө дээрх тандалтын судалгаанд үзэл санааг урьдчилан чиглүүлэх (урьдчилж тодорхой хүрээнд хайрцаглах, тодорхой чиглэлтэй хандах, ялгаварлаж гадуурхах) асуудал гарах магадлал багатай байсан. Судалгааны асуултын бүтэц тохиргоо нь харьцангуй объектив, төвийг сахисан байдаг тул үр дүн нь тандалт судалгааны өндөр ач холбогдолтой байдаг.

Судалгааны байгууллагуудын иргэдийн дунд хийсэн судалгааны дүнгээс харахад монголчуудын Хятадыг танин мэдэх хандлага доорх

хэдэн онцлогтой байна.

- 1) Монголчуудын Хятадад эерэгээр хандах хандлага нэлээн сул, ялангуяа ОХУ-тай харьцуулахад илт зөрүүтэй байна. Монголын иргэдийн талаас илүү хувь нь ОХУ-ыг Монголын хамгийн сайн түнш улс гэж үздэг, харин монголчуудын Хятад улсад дотно хандах хандлагын хувь хэмжээ нь “Туравдагч хөрш”-ийн орнууд болох Япон, АНУ, Европын холбооны зарим улсуудаас ч доогуур байна. Сант Маралын судалгаанд тэмдэглэснээр монголчуудын ердөө 3 хүрэхгүй хувь нь Хятадыг хамгийн сайн түнш гэж үздэг бөгөөд зарим үед энэ хувь хэмжээ 0.6% (2017 он) болтол буурдаг байна. SPDI-ын судалгаанд монголчуудын 41% нь Хятад улсад ямар нэг хэмжээгээр “дуртай” гэсэн байгаа ч 53% нь ямар нэг хэмжээгээр “дургүй” гэжээ. Харин ОХУ-д “дургүй” гэх хандлага ердөө 5%-тай байгаа юм.
- 2) Монголчуудын Хятадын талаар танин мэдэх ерөнхий ойлголт харьцангуй нийтлэг нэг түвшинд байна. Сант Маралын судалгаа Монголын нийгмийн хот хөдөөгийн ялгаа, янз бүрийн насны харилцан адилгүй ажил мэргэжил боловсролтой хүмүүсийг багтаасан байдаг бөгөөд нийгмийн янз бүрийн давхаргын Хятадын талаарх хандлага хол ялгаагүй нийтлэг шинжтэй байгаа юм. SPDR1, IRIM-ээс хийсэн хоёр судалгаатай харьцуулахад ч дээрх нийтлэг шинжийг харж болно. Энэ нь Монголын нийгэмд Хятадын

- талаарх харьцангуй сөрөг ойлголт нь тодорхой нийгмийн анги давхрага, бүлгийн өвөрмөц үзэгдэл биш, харин бүх нийтийн түгээмэл хандлага гэдгийг харуулж байна.
- 3) Монголчуудын Орос, Хятад руу чиглэсэн сэтгэл зүйн чиг хандлага харьцангуй тодорхой байна. SPDRI-ийн судалгаагаар Хятад, Орос гэсэн хоёр асуултанд хариулт өгөөгүй хүмүүсийн эзлэх хувь хамгийн бага (саарал), өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 90 гаруй хувь нь ямар нэг байдлаар “дуртай” эсвэл “дургүй” гэсэн байр сууриа илэрхийлсэн байна. Бусад улсуудын талаар хариулт өгөөгүй хүмүүсийн эзлэх хувь Хятад, Оросынхоос хамаагүй өндөр байна. Үүнд АНУ-д 17%, Японд 15%, Их Британид 31%, Энэтхэгт 34% нь хариулаагүй байна. Монгол Улс Хятад, Орос гэсэн хоёрхон хөрштэй хиллэдэг, хоорондоо тогтмол харилцаж харьцангуй ойр харилцдаг учраас монголчуудын хөршөө танин мэдэх чиг хандлагын ойлголт илүү тодорхой байна.
- 4) Монголчуудын Хятадын талаарх танин мэдэхүйд ухаалаг прагматик харилцаа болон иррациональ айдас зэрэгцэн оршиж байдаг. Нэг талаас, монголчууд Хятад бол эдийн засгийн чухал түнш гэдгийг хүлээн зөвшөөрч, Хятадын эдийн засгийн хөгжлийн «хурдны галт тэрэг»-т сууж үр шимийг нь хүртэхийг хүсдэг. Нөгөө талаар, Хятадаас хэт хараат байх нь улс үндэсний аюулгүй байдал, үүнд нийгэм, эдийн засаг, соёлын аюулгүй байдалд заналхийлнэ гэж болгоомжилдог учраас монголчууд үргэлж Хятадаас сэрэмжилэх сэтгэл зүйтэй байж ирсэн.
- 5) Монголчуудын Хятадад хандах хандлага сүүлийн жилүүдэд аажмаар сайжрах төлөв харагдаж байна. Сант Маралын 2014-2019 оны судалгаагаар хамгийн сайн түнш улсын хоёрдугаар сонголтонд Хятад гэж хариулах хувь хэмжээ АНУ, Японыг давсан ба 2019 оны судалгаагаар Хятад 23.2%, АНУ 13.2%, Япон 14.9%-тай байв. Ялангуяа Монголын залуусын Хятадын талаарх ойлголт харьцангуй эерэг байгаа нь анхаарал татаж байна. Сант Маралын 1997-2007 оны судалгаанд 18-24 насныхны 3.2% нь Хятадыг Монголын хамгийн сайн түнш улс гэж үздэг гэсэн бол 60 наснаас дээш насныхны 2.3% нь Хятадад дотно ханддаг гэж хариулсан байна. SPDRI ба IRIM-ийн судалгааг харьцуулахад, SPDRI-ын ерөнхий судалгаанд хамрагдагсдын 41% нь Хятадад ямар хэмжээгээр таатай ханддаг гэсэн бол IRIM-ийн залуучуудын дунд явуулсан судалгаанд энэ үзүүлэлт 51%-тай байна. Мөн SPDRI-ын судалгаанд оролцогчдын 53% нь Хятадад ямар нэг хэмжээгээр дургүй гэж хариулсан бол IRIM-ийн залуучуудад хийсэн судалгаанд уг үзүүлэлт 40%-тай байна.

2. Монголчуудын Хятадыг танин мэдэх үйл явц, хөгжил өөрчлөлтийн учир шалтгаан тайлбар

Антропологи-угсаатан судлал, олон улсын харилцааны салбар судлагдахуунд монголчуудын Хятадын талаарх ойлголт, Хятадыг танин мэдэх, хоёр талын харилцааны сэтгэл зүйн өнцгийг судалсан бүтээлүүд олон гэж хэлэхгүй ч байгаа хэдэн судалгаанууд нь нилээн гүнзгий судалсан байдаг. Эдгээр судалгаанууд монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтод нөлөөлж буй хүчин зүйлсийг олон талаас нь тандан судалдаг бөгөөд голчлон доорх чиглэлүүдээр онцгойлон судалдаг юм.

1) Түүх-соёлын хүчин зүйл

Франк Билле (Franck Billé)-ийн “Хятадаас айх үзэл: Санаа зоволт, хүчирхийлэл, Монгол хүний ижилслийг (Identity) бий болгох нь” (Sinophobia: Anxiety, Violence, and the Making of Mongolian Identity) ном нь нийгмийн антропологийн үүднээс хийгдсэн судалгаа бөгөөд уг ном зохиогчийн 2011 онд Кембрижийн их сургуулийг төгссөн докторын ажлын суурин дээр засварлан хийгдсэн бүтээл юм. Зохиогч өөрийнхөө Монгол Улсад урт хугацаанд явуулсан ажиглалт судалгаандаа үндэслэн Монголын нийгэм дэх Хятадын талаарх сөрөг ойлголтын талаар цогц, гүнзгий дүн шинжилгээ хийжээ. Ф.Биллигийн үзэж байгаагаар “Өнөөгийн монголчуудын Хятадын эсрэг үзэл бол хоёр талын урт хугацааны түүхэн эдрээтэй харилцааны онцлог, түүнээс

үлдсэн зүйл гэхээс илүүтэй ХХ зууны Монголын социализм, өөрчлөлт шинэчлэлийн үйл явцад үүссэн юм. Ялангуяа Хятад Зөвлөлтийн харилцаа муудсан үед Монголын эрх баригчид Хятадыг харлуулах сурталчилгаа хийж, Хятад сөрөг гэсэн дүр төрхийг үүсгэх болсон нь монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтод гүнзгий нөлөөлсөн байна. Хятад Зөвлөлтийн харилцааны нөлөөгөөр Монгол улс Хятадтай харилцахдаа харьцангуй урт хугацаанд сөрөг мэдээ мэдээлэлтэй, сөргөлдсөн байдалтай харилцаж байв. Монголын орчин үеийн үндэсний улс байгуулах явцад Монголыг оросчлох үйл явц дагалддаг бөгөөд Зөвлөлтийн нөлөөлөл ихэвчлэн Хятадыг нөлөөг багасгах, арилгахад чиглэсэн байдаг. Тиймээс Монголын орчин үеийн үндэстний улсын өвөрмөц шинж төрх бүрэлдэхдээ Зөвлөлтийн нөлөөг шингээж Хятадын эсрэг үзлийг бий болгох гэсэн хоёр чухал чиглэлтэй байсан.

Ф.Билл-гийн Монголд судалгаа хийж байх хугацаа нь 1990-ээд оноос хойших Монголд Хятадын эсрэг үзэл дээд цэгтээ хүрсэн (2011 оны орчим) үе байсан юм. Тиймээс судлаач өөрийн тандалт, ажиглалт, судалгааны туршлага дүн шинжилгээндээ үндэслэн Монголын нийгэмд түгээмэл байдаг Хятадын эсрэг хандлагын олон жишээг дурджээ. Тухайлбал, өнөөгийн монголчууд Хятад улс болон хятадуудын талаарх ойлголт дутмаг, монголчууд дээрх ойлголтыг шууд

туршлагаас мэдэж авахаас илүүтэйгээр өдөр тутмын албан бус зүйлсээс, жишээ нь гэр бүлийн боловсрол, хэвлэл мэдээлэл, цахим нийгмийн сүлжээ зэргээс олж авдаг учраас Хятадын талаарх ойлголт нь өрөөсгөл сэтгэлгээнд суурилсан “төсөөллийн” өнгө аястай хэмээн Ф.Билли онцолсон байна.

Харин судлаач Сара Жексон (Sara Jackson) эртний түүх, тухайлбал Манж Чин улсын сүүл үе, Чин гүрний Монголыг захирч байсан үеийн шарх нь өнөөг хүртэл монголчуудын Хятадын талаарх ойлголтод чухал нөлөөг үзүүлж байдаг⁵ гэсэн байр суурьтай байна. Зарим судлаач монголчуудын Хятадын талаарх ойлголт, үл итгэх байдал нь илүү урт түүхэн үйл явц, соёл иргэншил, соёлын ялгаатай байдлаас үүдэлтэй гэж тайлбарласан байдаг. Жишээлбэл, Баабар нүүдлийн болон суурьшмал соёл иргэншлийн эсрэг тэсрэг байдал харилцан нөлөөлөх хэв шинж нь монголчуудын Хятадын талаарх ойлголтыг бүрэлдүүлэхэд нөлөө үзүүлдэг талаар онцолсон байдаг.⁶ Моррис Россоби-гийн үзэж байгаагаар хоёр үндэстний хооронд 2000 орчим жилийн турш давтамжтай үргэлжилсэн зөрчилдөөн, дайсагналаас үүдсэн үл итгэлцэл нь өнөөгийн Хятад, Монголын харилцаанд нөлөөлсөөр байна⁷ гэсэн байдаг.

2) Бодит нөхцөл байдлын хүчин зүйл

Жеффри Ривс-ийн Лондонгийн Улс төр эдийн засгийн сургуульд бичсэн “Монголын төрийн сул дорой байдал, гадаад бодлого болон БНХАУ-аас хамааралтай байдал” (Mongolian State Weakness, Foreign Policy, and Dependency on the People’s Republic of China) (2010) хэмээх докторын ажил нь олон улсын харилцааны өнцгөөс Монгол Хятадын харилцааг судалсан судалгаа юм. 1990-ээд оноос хойш Монголд үндэсний үзэл сэргэж улам бүр үндсэрхэг шинжтэй болж гадныхныг гадуурхах үзэл давалгаалах болсон, уг гадуурхах үзэл голчлон Хятад улс руу чиглэдэг ба энэ нь Монголын эдийн засаг Хятадаас ихээхэн хамааралтай байдагтай холбоотой хэмээн Жеффри Ривс дурджээ. Монгол Улсын засгийн газар болон зарим ашиг сонирхлын бүлгүүд прагматик байдлаар Хятадтай харилцаж эдийн засгийн хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд ихээхэн анхаарч байгаа ч эдийн засгийн хараат байдал нь дотоодын эдийн засгийн хөгжил, байгалийн баялгийн ашиглалт, хүрээлэн буй орчны бохирдол, хүн ам соёл зэрэгт сөргөөр нөлөөлж үр дагавар улам бүр нэмэгдэх болно гэж Монголын нийгмийн цөөнгүй хэсэг үзэж байгаа юм. Монголын нийгмийн онцлог шинж чанар (social identity) болон засгийн удирдлагын бүтэц (the structure of governance) хоорондын холбоо салсан нь өнөөгийн Монголын

5 Sara L.Jackson and Devon Dear, “Resource extraction and national anxieties: China’s economic presence in Mongolia”, *Eurasian Geography and Economics*, Vol.57, No.3, 2016, 343-373.

6 В.Баабар, *Twentieth Century Mongolia*, Cambridge: The White Horse Press, 1999, p9.

7 Morris Rossabi, *Modern Mongolia: From Khans to Commissars to Capitalists*, Berkeley: University of California Press, 2005.

сул дорой байдлын үндсэн шалтгаан болоод байгаа бөгөөд энэхүү байдал Хятадаас хамаарах эдийн засгийн хамаарал нэмэгдэх тусам Монголыг үр дүнтэй гаргалгаа олоход хүндрэлтэй болгож байна гэж Жеффри Ривс үзсэн байна.

Грегор Гроссман (Gregor Grossman) “Монгол Хятадын хамтын ажиллагаа гүнзгийрснээр Монгол улс Хятадаас эдийн засгаараа хамааралтай болсоор байгаа нь тус улсын санааг зовоосон гол асуудал болж байна. Цаашид “Бүс ба Зам” хамтын ажиллагаагаар хоёр улсын харилцаа холбоо улам нэмэгдэнэ, үүнтэй зэрэгцэн Монголын Хятадтай хамтран ажиллахад үүсдэг эдийн засаг, улс төр, байгаль орчны санаа зовоосон асуудлууд байсаар байх болно”⁸ хэмээн үзэж байна. Хятадын судлаачид Пан Чинь (庞琴), Лян И-ин (梁意颖), Пань Жюньхао (潘俊豪) нар олон хэмжээст шугаман загвар (Multilevel linear model)-ын аргаар Зүүн Азийн 9 орны Хятадтай хийх эдийн засаг худалдааны хамаарал болон тухайн орнуудын иргэд олон нийтээс Хятадад өгсөн үнэлгээг харьцуулан судлахад Монгол, Япон, Өмнөд Солонгос улсууд Хятадтай эдийн засгаараа өндөр хамааралтай байгаа боловч уг гурван улсын иргэд олон нийт Хятадад хамгийн их сөрөг хандлагатай байна. Эдгээр улстай харьцуулахад Филиппин, Камбож,

Индонез, Малайз, Сингапур, Тайланд улсуудын Хятадаас хамаарах эдийн засгийн хамаарал харьцангуй бага байдаг ч тухай орнуудын иргэдийн Хятадад хандах хандлага харьцангуй эерэг байсан байна.⁹

3) Сэтгэл зүй-Сэтгэлгээний хүчин зүйл

Зарим эрдэмтэд монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтод Монголын нийгэм дэх Хятад руу чиглэсэн сэтгэлгээний орчин уур амьсгал ихээхэн нөлөө үзүүлдэг талаар онцлон тэмдэглэдэг. Уг орчин уур амьсгал нь түүх, соёл, гадны нөлөөлөл зэрэг олон хүчин зүйлсийн урт хугацааны харилцан үйлчлэлээр бий болж бүрэлдсэн сэтгэлгээний орчин байдаг. Жишээлбэл, Ж.Мэндийн үзэж байгаагаар түүхийн ой санамж, монгол соёлыг дээдлэх үзэл (ялангуяа удам угсааны цэвэр ариун байдлыг онцлох), дотоод гадаадын хүчин зүйл (дотоодын болон гадны хүчнүүд монголчуудын Хятадад таагүй ханддаг сэтгэл зүйг ашиглаж эдийн засгийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх) хамтын үйлчлэл дундаас бүрэлддэг монголчуудын Хятад улс, хятадуудын талаарх далд сэтгэлгээ нь монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтод нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл юм¹⁰ гэж дүгнэсэн байдаг.

8 Gregor Grossman, “One Belt One Road and the Sino-Mongolian Relationship”, *Blickwechsel*, April 2017.

9 Пан Чинь, Лян И-ин, Пань Жюньхао. Хятадын эдийн засгийн нөлөө ба Зүүн Азийн орнуудын иргэдийн Хятад улсад өгсөн сэтгэгдэл үнэлгээ - Эдийн засгийн үр ашгийн хүртээмж ба хөгжлийн үзлийн зохицуулалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ, “Дэлхийн эдийн засаг ба улс төр”, 2017 он 2-р хэвлэл, тал 130-154. 庞琴, 梁意颖, 潘俊豪, 《中国的经济影响与东亚国家民众对评价一经济受惠度与发展主义的调节效应分析》, 《世界经济与政治》, 2017年第2期, 130-154页。

10 Jargalsaikhan Mendee, “Lingering anti-Sinic Sentiments in Post-Communist Mongolia: Why dislike the

Австралийн эрдэмтэн Ли Нарангуа Монголын Хятадтай явуулж буй дипломат харилцааг “болгоомжилсон дипломат ажиллагаа” (preventive diplomacy) бөгөөд энэхүү бодлогын цаад гол учир шалтгаан сэтгэлгээний логик нь Монголын орчин үеийн түүхийн сургамж, геополитик газарзүйн онцгой шинжээс үүссэн болгоомжлох сэтгэл зүй¹¹ гэж тодорхойлсон байдаг.

Монголын зарим судлаач өнөөгийн Монгол Хятадын харилцаанд сэтгэлзүй танин мэдэхүйн хүчин зүйл чухал нөлөө үзүүлдэг хэмээн онцолсон байдаг. Судлаач Д.Зоригт хэлэхдээ “Монголчуудын Хятадаас болгоомжлох сэтгэл зүй нь түүхээс улбаатай бөгөөд Хятадын хүч нөлөө нэмэгдэхийн хэрээр Монголын нийгэмд болгоомжлох сэтгэл зүй улам бүр нэмэгдсээр байх болно. Хятад, Монголын харилцаа шинэ эрин зуунд шилжин орсноор талуудын харилцан итгэлцлийг бий болгох нь онцгой чухал болж байна”¹² хэмээсэн бол судлаач Я.Ганбаатар “Хятадын үзүүлж буй нөлөө бол бүх талыг хамарсан нөлөөлөл, үүнээс Монголын эдийн засаг, үндэсний соёл, сэтгэлгээ үзэл санаанд үзүүлэх нөлөөлөлд онцгой анхаарал хандуулах ёстой, гэхдээ энэ нөлөөллийг “Хятадын аюул” гэж ойлгож дүрслэх нь зохимжгүй”¹³ хэмээн дурдсан байдаг.

4) Харьцуулсан судалгааны арга

Өгүүллийн эхний хэсэгт дурдсан тоон үзүүлэлтээс дүгнэхэд монголчууд Хятад, Орос гэсэн хоёр хөршөө танин мэдэх ойлголтын зөрүү их байгаа нь харагдаж байна. Өмнө дурьдсанчлан зарим судлаачид монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтод орчин цагийн түүхэн сургамж (XX зууны түүх) нөлөөлдөг талаар онцгойлон дурдсан байдаг. Харин судлаач Грегори Деллаплас (Grégory Delaplace) энэ талаар өөр байр суурьтай байна. Тэрбээр, үнэндээ XX зууны дийлэнх хугацааг монголчууд Зөвлөлтийн эрхшээлд өнгөрүүлсэн ба монголчуудын үндэсний үзэл, соёл уламжлал хүчтэй хавчигдан гадуурхагдсан. Мөн Зөвлөлтөөс эхлүүлсэн улс төрийн цэвэрлэгээг Монголд хийж их хэлмэгдүүлэлтийг явуулсан. Гэтэл монголчууд яагаад өнөөгийн Орос улсад хамгийн их таатай хандаж байна вэ? Монголчууд яагаад Зөвлөлтийн “сайн”-ыг нь сонгон санаж, “муу”-г нь мартаж байна вэ? Эсрэгээрээ монголчуудын Хятадын тухай түүхэн дурсамж яагаад үргэлж харьцангуй сөрөг талдаа байдаг вэ? Эдгээр асуултад цогцоор нь хариулахын тулд сүүлийн жилүүдэд Монголын нийгэмд үүссэн Хятадын эсрэг үзлийн бодит шалтгаан үр дагаварыг судлахаас гадна монголчууд яагаад өөрсдийнхөө социализмын

Chinese”, In: Voices from Central Asia 19, 2015, 1-15.

11 Li.Narangoa, “Mongolia and Preventive Diplomacy: Haunted by History and Becoming Cosmopolitan”, In: Asian Survey 49 (2), 2009, 358-379.

12 Д.Зоригт, “Хамтын ажиллагаанд итгэлцэл чухал”, Монгол Хятадын харилцаа жарнаас жаранд, Улаанбаатар, “Админ” ХХК хэвлэлийн газар, 2010, тал 64-75.

13 Я.Ганбаатар, “Хятадын аюул уу, Хятадын нөлөөлөл үү?”, Монгол Хятадын харилцаа жарнаас жаранд, Улаанбаатар, “Админ” ХХК хэвлэлийн газар, 2010, тал 45-51.

түүхийн талаар бодитой, бүрэн ойлголтгүй байдгийн учир шалтгаан, Монголын хоёр том хөрштэйгээ

харилцсан урт хугацааны түүхэн харилцааг ойлгон судлах шаардлагатай гэсэн санааг илэрхийлсэн байдаг.¹⁴

3. Дүгнэлт

Монголчуудын дунд явуулсан Хятадын талаарх танин мэдэх судалгааны босоо хэвтээ харьцуулалтаас дүгнэхэд хоёр талын харилцаанд танин мэдэхүйн ойлголтын болон сэтгэлзүйн дотнослын хангалттай суурь байхгүй нь ажиглагдаж байна. Хэдийгээр Монгол Хятадын өнөөгийн харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн боловч ерөнхий чиг хандлага нь «тэнцвэргүй» байдалтай хөгжиж байна. Улс төр, гадаад харилцаа нь тогтвортой сайжирч, эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа хурдацтай хөгжиж, албан ёсны соёлын солилцоо арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж байгаа ч хоёр улсын ард түмний харилцан ойлголцол, эерэгээр танин мэдэх хандлага харьцангуй сул байсаар байна. Энэ нь өнөөгийн хоёр талын харилцааны итгэлцэл, олон нийтийн дэмжлэг хангалттай бат бөх биш болохыг илтгэж байна.¹⁴

Нийгмийн бодит байдал буюу нийгэмд гарч буй үзэгдэл нь ихэвчлэн олон хүчин зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүн байдаг. Академик талаас нь харахад Монголын Хятадыг танин мэдэх ойлголтын судалгаа нэг судлагдахуунтай судалгаа биш бөгөөд ялгаатай өөр хүчин зүйлсийн дундаас зарим нь түүхийн үүрэг ролийг, зарим нь бодит нөхцөл байдлын нөлөөг,

зарим нь сэтгэлзүй сэтгэлгээний хүчин зүйлийг чухалчилж онцолсон байдаг. Үүнээс зарим судалгаа нь гүнзгий харьцангуй объектив шинжтэй байдаг ч зарим нь түүх соёлын талыг хэт тусгасан тодорхой бус тайлбартай, барууны соёлын хоёрдмол шинж (dualism) эсхүл олон төрөлт шинж (heterogeneity) талаас нь тодорхойлж, нүүдэлчдийн соёл иргэншил болон суурьшмал тариалангийн соёл иргэншлийн урт хугацааны түүхэн харилцааны сөргөлдсөн шинж чанарыг хэт дөвийлгөсөн байдаг. Зарим судалгаанд Монголыг сул дорой жижиг улс гэсэн байр сууринаас Монголын Хятадыг танин мэдэх ойлголтыг дүгнэн судалсан байдаг. Үүнээс гадна судалгаануудын нийтлэг орхигдуулдаг гадны хүчин зүйл бол Монгол ардчилсан улс болж шилжин өөрчлөгдсөнөөс хойш барууны тогтолцоо соёл сэтгэлгээ шашны нөлөө Монголын нийгэм олон нийтийн үзэл санаа, соёл сэтгэхүйд шингэсэн байдаг ба энэ нь монголчуудын Хятадыг танин мэдэх ойлголтод нөлөөлдөг талаарх судалгаа юм. Монголын Хятадыг танин мэдэх ойлголтын өнөөгийн нөхцөл байдал нь түүх-сэтгэлзүй, бодит тулгарч буй хүчин зүйлүүд (голчлон худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд гарч буй зарим асуудлууд), гадаад хүчин зүйлсийн

14 Grégory Delaplace, "Parasitic Chinese, vengeful Russians: ghosts, strangers, and reciprocity in Mongolia", *Journal of the Royal Anthropological Institute*, Vol.18 Issue Supp S1, Jun 2012, 131-144.

(Барууны орнуудын үзэл суртал, тогтолцоо болон соёл сэтгэлгээний нөлөөнд автсан байдал) хамтын үйлчлэл дундаас бүрэлдсэн үр дүн юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Хятад хоёр улс “Бүс ба зам”-ын бүтээн байгуулалтын хүрээнд харилцан ашигтай хамтын ажиллагаа явуулахыг зорьж байна. Иргэд хоорондын найрсаг харилцаа бол “Бүс ба зам” бүтээн байгуулалтын чухал хэсэг төдийгүй хамтын ажиллагааны гол суурь юм. Монгол Хятадын харилцааны сэтгэлгээний ойлголцол найдвартай итгэлцлийн суурийг хэрхэн сайжруулах нь хоёр талын өмнө тулгарч буй нийтлэг асуудал юм.

Монгол Хятадын эрдэм шинжилгээний байгууллагууд хоёр талын харилцан ашигтай, хамтдаа хожих хамтын ажиллагааг шат ахиулахад бодит хувь нэмрээ оруулах хэрэгтэй байна. Судалгааны байгууллагууд хамтарч хоёр талын харилцаанд сургамж болсон сонгодог жишээнүүдийг салбар бүрээр олон талаас нь дүгнэн шинжилж, талуудын харилцах явцад үүсдэг сэтгэлзүйн болон сэтгэлгээний асуудлыг иж бүрнээр сайтар судлаж, хоёр улсын харилцан ойлголцол, итгэлцлийг хэрхэн гүнзгийрүүлэх талаар онол судалгаанд суурилсан бодлогын зөвлөмжийг боловсруулах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Franck Billé. 2014. *Sinophobia: Anxiety, Violence, and the Making of Mongolian Identity*, Honolulu: University of Hawai'i Press.
2. Jeffery Reeves. 2010. *Mongolian state weakness, foreign policy, and dependency on the People's Republic of China*. PhD thesis, The London School of Economics and Political Science (LSE).
3. Morris Rossab. 2005. *Modern Mongolia: From Khans to Commissars to Capitalists*, Berkeley: University of California Press.
4. Gregor Grossman. “One Belt One Road and the Sino-Mongolian Relationship”, *Blickwechsel*, April 2017.
5. Grégory Delaplace. “Parasitic Chinese, vengeful Russians: ghosts, strangers, and reciprocity in Mongolia”, *Journal of the Royal Anthropological Institute*, Vol.18 Issue Supp S1, Jun 2012.
6. Jargalsaikhan Mendee. “Lingering anti-Sinic Sentiments in Post-Communist Mongolia: Why dislike the Chinese”, In: *Voices from Central Asia* 19, 2015, 1-15.
7. Li.Narangoa. “Mongolia and Preventive Diplomacy: Haunted by History and Becoming Cosmopolitan”, In: *Asian Survey* 49 (2), 2009, 358-379.
8. Prohl, W. and L. Sumati. 2007. *People's Perception of Mongolia's Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007*, Ulaanbaatar: Munkhiin Useg Co.Ltd.

9. Sara L.Jackson and Devon Dear. “Resource extraction and national anxieties: China’s economic presence in Mongolia”. *Eurasian Geography and Economics*, Vol.57, No.3, 2016.
10. Д.Зоригт. “Хамтын ажиллагаанд итгэлцэл чухал”, *Монгол Хятадын харилцаа жарнаас жаранд*, Улаанбаатар, “Админ” ХХК хэвлэлийн газар, 2010,64-75.
11. Я.Ганбаатар. «Хятадын аюул уу, Хятадын нөлөөлөл үү?», *Монгол Хятадын харилцаа жарнаас жаранд*, Улаанбаатар, “Админ” ХХК хэвлэлийн газар, 2010, 45-51.
12. Пан Чинь, Лян И-ин, Пань Жюньхао. Хятадын эдийн засгийн нөлөө ба Зүүн Азийн орнуудын иргэдийн Хятад улсад өгсөн сэтгэгдэл үнэлгээ - Эдийн засгийн үр ашгийн хүртээмж ба хөгжлийн үзлийн зохицуулалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ, *Дэлхийн эдийн засаг ба улс төр*, 2017 он 2-р хэвлэл, 130-154.
庞琴, 梁意颖, 潘骏豪, 《中国的经济影响与东亚国家民众对评价—经济受惠度与发展主义的调节效应分析》, 《世界经济与政治》, 2017年第2期, 130-154页。

A Review of the Research on Mongolia's Perception of China

B.Shurentana

PhD, lecturer in Mongolian Study Center, Inner Mongolia University, Hohhot, China, coral316@163.com

Abstract: *Mutual perception is an important indicator of the degree of closeness between countries, and it can more intuitively reflect the degree of mutual favorability between the two peoples and the perception of each other's national image. Mongolia's perception of China is an important fundamental aspect in the bilateral relations. This article reviews and examines the current research status of the given topic in academic circles. In general, (1) The public opinion surveys of some research institutes on Mongolia's perception of China are relatively objective and neutral, so their survey results have higher reference value and application value. (2) Regarding the specific studies of Mongolia's perception of China, some studies are relatively neutral, objective and of keen insights, and some are difficult to divorce from the perspective of the 'self' or the western interpretation mode, often presuppose their positions and tend to place too much emphasis on historical and cultural factors. Mongolia's perception of China is the result of the interaction of various factors mainly including history, emotion/psychology, realistic issues, and external factor.*

Keywords: *Mongolia; Perception of China; Literature Review*

<i>The day of submission:</i>	<i>2021.09.14</i>
<i>Completion of review:</i>	<i>2021.10.29</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2021.11.25</i>